



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/143/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.dornogovi.audit.mn

Дорноговь аймаг

2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 70523020

Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn

Аудитор:

Т.Мөнхтогтох

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20

Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2020.02.19 № 1-6/85
танай _____ -ны № _____ -т

ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ СУМ
ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.ГАНБААТАР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2.1. Оршил

Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дарга Л.Ганбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 05-аас 2020 оны 02 дугаар сарын 06-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 15 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Шүүн таслах үйл ажиллагаа хуулийн хүрээнд шударга байхад оршино.

Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шүүхийг өдөр тутмын үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлөөр хангах;
- Шүүхийн хөдөлмөр зохион байгуулалт, дотоод журмын биелэлтэд хяналт тавих;
- Шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, бүртгэх;
- Шүүхийн бичиг хэрэг, захидал харилцаа, шуудан, архивын үйл ажиллагааг зохион байгуулах;
- Шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээ авах;
- Хэргийн эд мөрийн баримтыг хадгалах, зөөвөрлөх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоол “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2019 оны 277 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай”

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “aculous” программ хангамж ашигладаг байна.

Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 32 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн Нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 405,186.4 мянган төгрөгөөс тооцон 4,051.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 5,642.9 мянган төгрөгөөр тооцсон нь ажил гүйлгээний цар хүрээ багатай холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,916.3 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	134.6	0.0	-134.6
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	27,400.0	28,960.9	1,560.9
Үндсэн хөрөнгө	576,387.8	559,045.3	-17,342.5
Нийт хөрөнгө	603,922.5	588,006.2	-15,916.3
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	603,922.5	588,006.2	-15,916.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	603,922.5	588,006.2	-15,916.3

Авлагаа барагдуулсан байна. Авлага дансны үлдэгдэлд 2018 онд үүссэн 134.6 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага байсан.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь аж ахуйн материал нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 17,342.5 мянган төгрөгөөр буурсан бөгөөд хөрөнгийн элэгдлийг бодуулснаас шалтгаалж байна. 1,925.5 мянган төгрөгийн хөрөнгийг Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс шилжүүлэн авсан байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн болон акталсан хөрөнгө байхгүй.

Биет бус хөрөнгөд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 588,006.1 мянган төгрөг болж 15,916.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт гараагүй байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 6 зориулалтад 545,231.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 544,231.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний зардалд, 1,000.0 мянган төгрөгийг бусад урсгал шилжүүлэгт зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 545,231.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 543,971.2 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байна. /цалин хөлс болон нэмэгдэл урамшил 388,632.9 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 48,765.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 35,249.7 мянган төгрөг, хангамж бараа материал 33,441.5 мянган төгрөг, эд хогшил худалдан авах 20,000.0 мянган төгрөг, томилолт зочны зардал 9,395.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 6,986.0 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 1,000.0 мянган төгрөг/ нийт дүнгээр 1,259.7 мянган төгрөг хэмнэгдэж үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааны зориулалтаар Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас 1,000.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Бичиг хэргийн зардал буюу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гарын авлага, тараах материалд зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 4 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 7 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2,550.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1 алдааг залруулж, 130.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 2,420.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 130.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 130.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Шүүхийн тамгын газрын дарга урамшуулал олгох тушаал гаргахдаа тушаалын хавсралтад өөрийн нэрийг оруулж 130.0 мянган төгрөгийн урамшуулал авсан нь Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 “төсвийн шууд захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч нь харьяалагдах дээд шатныхаа төсвийн захирагчтай төсвийн жил эхлэхээс өмнө үр дүнгийн гэрээ байгуулна”, 40.4.2 “үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үр дүнгийн гэрээг дүгнэх эрх бүхий этгээд нь хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд урамшуулах, хариуцлага тооцох арга хэмжээг хэрэгжүүлнэ”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 “албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” заалттай нийцэхгүй үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн 2,420.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 146 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 0 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 100.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосноос 100.0 мянган төгрөгийг барагдуулсан байна.

Зөвлөмж өгөөгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1 Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

1,150.0 мянган төгрөгийн монтажны засварын ажлыг гэрэл цахилгааны зардлаас шилжүүлсэн.

Энэ нь (үнэн зөв байдал) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал батлах тухай” гэрэл цахилгаан “үйлчлэгч байгууллагатай байгуулсан гэрээ болон цахилгааны эрчим хүчийг хэмжих тоолуурын заалтын дагуу байгууллагын хэрэгцээнд ашигласан цахилгааны эрчим хүчний (гэрэл, цахилгаан) төлбөр, өөрийн эх үүсвэрээр цахилгааны эрчим хүчээр хангахад гарсан зардлыг харуулна” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчих.

1.3 Өгсөн зөвлөмж:

Шаардлагатай урсгал засварын тооцоо судалгаа гаргаж, төсвийн төсөлд тусгаж батлуулах.

2 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

2.1 Илрүүлэлт:

Аж ахуйн материалын дансанд 770.7 мянган төгрөгийн сэлбэгийг орлого авч зарцуулсан.

Энэ нь (Топилуулга ба тодруулга) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт 4 дүгээр зүйлийн 4.16 “бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө”, 2014 оны 5 дугаар тушаалын 5 дугаар хавсралт 35 дугаар зүйлийн 35400 хангамжийн материал нь “бичиг хэргийн материал, аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл, түлш шатах тослох материал, барилгын засварын материал, хүнсний материал” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчих.

2.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалын 5 дугаар хавсралтад заасан дансны нэр төрлийн дагуу хөрөнгийн ангиллыг зөв бүртгэх.

3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

3.1 Илрүүлэлт:

Нормын хувцасны зардлаас 500.0 мянган төгрөгийг гаргаж бараа материалд орлого аваагүй шууд зардалд бичсэн.

Энэ нь (Иж бүрэн байх) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 “Нягтлан бодох бүртгэлд аж ахуйн бүх ажил гүйлгээ, бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, бүх орлого, бүх зардал, НББОУС-аар тогтоосон бусад зүйлсийг заавал бүртгэнэ”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “НББ-ийн дансны заавар”-ын 4.21-т заасныг зөрчсөн байна.

3.2 Эрсдэл:

Хөрөнгийн хадгалалт хамгаалалт, дотоод хяналтын тогтолцоо сулрах, төсвийн сахилга бат алдагдах, бараа дутах, шамшигдах.

3.3 Өгсөн зөвлөмж:

2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн бараа материалын тайланд 500.0 мянган төгрөгийн хувцсыг бүртгэх, цаашид Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын дагуу байгууллагын дансаар дамжиж буй ажил гүйлгээнүүдийг бараа материалын дансаар дамжуулж орлого, зарлагад бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>27,534,657.50</u>	<u>28,960,914.50</u>
33	АВЛАГА	134,606.00	00.00
335	Бусад авлага	134,606.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	134,606.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	27,400,051.50	28,960,914.50
354	Хангамжийн материал	27,400,051.50	28,960,914.50
35410	Бичиг хэргийн материал	6,087,086.00	5,857,989.00
35420	Аж ахуйн материал	20,442,965.50	22,862,925.50
35440	Түлш, шатах тослох материал	870,000.00	240,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>576,387,845.11</u>	<u>559,045,277.77</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	576,387,845.11	559,045,277.77
392	Биет хөрөнгө	561,387,845.11	544,045,277.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	520,774,830.00	520,774,830.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-9,965,166.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	61,517,151.00	61,517,151.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-61,517,151.00	-61,517,151.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	118,583,217.01	122,923,774.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	-102,394,209.15	-112,153,234.07
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,912,748.60	53,462,748.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28,824,417.35	-34,140,800.77
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,822,700.00	1,822,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-10,000.00	-237,530.00
39217	Ном	1,522,976.00	1,557,956.00
393	Биет бус хөрөнгө	15,000,000.00	15,000,000.00
39301	Програм хангамж	825,000.00	825,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-825,000.00	-825,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	15,000,000.00	15,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>603,922,502.61</u>	<u>588,006,192.27</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>603,922,502.61</u>	<u>588,006,192.27</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	603,922,502.61	588,006,192.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	164,647,239.77	164,647,239.77
51101	Өмч: - төрийн	164,647,239.77	164,647,239.77
512	Хуримтлагдсан үр дүн	-12,856,928.36	-28,773,238.70
51210	Өмнөх үеийн үр дүн	-12,856,928.36	-12,856,928.36
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-15,916,310.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	452,132,191.20	452,132,191.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>603,922,502.61</u>	<u>588,006,192.27</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	514,686,336.00	548,379,287.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,812,730.00	2,148,287.00
120	Нийтлэг татварын бус орлого	24,812,730.00	2,148,287.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,812,730.00	2,126,987.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	24,812,730.00	2,126,987.00
120009	Бусад орлого	00.00	21,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	489,873,606.00	546,231,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	489,739,000.00	545,231,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	489,739,000.00	545,231,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	134,606.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	134,606.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	505,991,540.72	564,295,597.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	505,991,540.72	564,295,597.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	505,458,399.72	562,035,853.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	342,635,213.00	388,632,947.00
210101	Үндсэн цалин	271,774,266.00	290,004,431.00
210102	Нэмэгдэл	46,747,947.00	60,578,091.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,837,000.00	15,933,000.00
210104	Урамшуулал	8,276,000.00	22,117,425.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,116,200.00	48,900,506.00
210201	Тэтгэврийн даатгал	28,056,100.00	33,248,944.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,265,000.00	3,862,733.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,612,000.00	2,967,591.00
210204	Ажилгүйдлийн даатгал	653,000.00	997,954.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,530,100.00	7,823,284.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,845,531.00	35,249,700.00
210301	Гэрэл, цахилгаан	5,375,889.00	5,226,211.00
210302	Түлш, халаалт	26,842,199.00	26,588,857.00
210303	Цэвэр, бохир ус	2,627,443.00	3,434,632.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,038,048.75	34,137,193.00
210401	Бичиг хэрэг	7,331,804.00	10,722,167.00
210402	Тээвэр, шатахуун	10,372,200.00	13,757,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,981,056.00	5,028,350.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,880,988.75	4,051,276.00
210408	Бараа материал акталсны зардал	472,000.00	338,200.00

2105	Нормативт зардал	500,000.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,473,535.00	14,100,782.00
210604	Урсгал засвар	11,473,535.00	14,100,782.00
2107	Томилолт, зочны зардал	7,395,200.00	9,395,200.00
210702	Дотоод албан томилолт	7,395,200.00	9,395,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,039,559.00	5,851,421.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,651,949.00	3,745,421.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	839,850.00	1,618,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	193,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	247,500.00
210807	Газрын төлбөр	17,760.00	25,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,415,112.97	25,268,104.34
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,952,950.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,462,162.97	25,268,104.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	533,141.00	2,259,744.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	533,141.00	1,259,744.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	533,141.00	1,259,744.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>8,694,795.28</u>	<u>-15,916,310.34</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,370,262.60	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	4,370,262.60	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-4,370,262.60	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>4,324,532.68</u>	<u>-15,916,310.34</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	495,191,755.00	546,231,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	495,191,755.00	546,231,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	489,739,000.00	545,231,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	489,739,000.00	545,231,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,452,755.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,452,755.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	490,961,955.00	540,231,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	490,961,955.00	540,231,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	484,976,059.00	537,971,256.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	342,635,212.00	388,632,948.00
210101	Үндсэн цалин	271,774,365.00	290,004,432.00
210102	Нэмэгдэл	46,747,847.00	60,578,091.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,837,000.00	15,933,000.00
210104	Урамшуулал	8,276,000.00	22,117,425.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,116,200.00	48,765,900.00
210201	Тэтгэврийн даатгал	28,056,100.00	33,242,659.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,265,000.00	3,826,453.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,612,000.00	2,943,287.00
210204	Ажилгүйдлийн даатгал	653,000.00	991,880.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,530,100.00	7,761,621.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,845,531.00	35,249,700.00
210301	Гэрэл, цахилгаан	5,375,889.00	5,226,211.00
210302	Түлш, халаалт	26,842,199.00	26,588,857.00
210303	Цэвэр, бохир ус	2,627,443.00	3,434,632.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,946,106.00	34,441,508.00
210401	Бичиг хэрэг	10,616,200.00	12,146,200.00
210402	Тээвэр, шатахуун	11,127,200.00	12,127,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,981,056.00	5,090,750.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,221,650.00	4,837,358.00
2105	Нормативт зардал	500,000.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,270,200.00	14,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,270,200.00	00.00
210604	Урсгал засвар	12,000,000.00	14,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,395,200.00	9,395,200.00

210702	Дотоод албан томилолт	7,395,200.00	9,395,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,267,610.00	6,986,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,880,000.00	4,880,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	839,850.00	1,618,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	193,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	247,500.00
210807	Газрын төлбөр	17,760.00	25,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,000,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,985,896.00	2,259,744.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,452,755.00	1,000,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,452,755.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	533,141.00	1,259,744.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	533,141.00	1,259,744.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>4,229,800.00</u>	<u>6,000,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>4,229,800.00</u>	<u>6,000,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>4,229,800.00</u>	<u>6,000,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>4,229,800.00</u>	<u>6,000,000.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,229,800.00	6,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-4,229,800.00</u>	<u>-6,000,000.00</u>

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	149,647,239.77	149,012,299.92	-17,181,461.04	281,478,078.65
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	149,647,239.77	149,012,299.92	-17,181,461.04	281,478,078.65
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	303,119,891.28	00.00	303,119,891.28
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	15,000,000.00	00.00	00.00	15,000,000.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	4,324,532.68	4,324,532.68
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,647,239.77	452,132,191.20	-12,856,928.36	603,922,502.61
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,647,239.77	452,132,191.20	-12,856,928.36	603,922,502.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	164,647,239.77	452,132,191.20	-12,856,928.36	603,922,502.61
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-15,916,310.34	-15,916,310.34
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,647,239.77	452,132,191.20	-28,773,238.70	588,006,192.27

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	545,231,000.00	543,971,256.00	1,259,744.00	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	545,231,000.00	543,971,256.00	1,259,744.00	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	544,231,000.00	542,971,256.00	1,259,744.00	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	390,126,700.00	388,632,948.00	1,493,752.00	99.6
210101	Үндсэн цалин	296,424,900.00	290,004,432.00	6,420,468.00	97.8
210102	Нэмэгдэл	66,329,300.00	60,578,091.00	5,751,209.00	91.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,874,000.00	15,933,000.00	-2,059,000.00	114.8
210104	Урамшуулал	13,498,500.00	22,117,425.00	-8,618,925.00	163.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,765,900.00	48,765,900.00	00.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	34,080,800.00	33,242,659.00	838,141.00	97.5
210202	Тэтгэмжийн даатгал	3,671,300.00	3,826,453.00	-155,153.00	104.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,937,000.00	2,943,287.00	-6,287.00	100.2
210204	Ажилгүйдлийн даатгал	734,300.00	991,880.00	-257,580.00	135.1
210205	Эрүүл мэндийн даатгал	7,342,500.00	7,761,621.00	-419,121.00	105.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,249,700.00	35,249,700.00	00.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	5,448,200.00	5,226,211.00	221,989.00	95.9
210302	Түлш, халаалт	26,821,400.00	26,588,857.00	232,543.00	99.1
210303	Цэвэр, бохир ус	2,980,100.00	3,434,632.00	-454,532.00	115.3
2104	Хангамж, бараа материалын зардал	33,197,500.00	33,441,508.00	-244,008.00	100.7
210401	Бичиг хэрэг	10,616,200.00	11,146,200.00	-530,000.00	105.0
210402	Тээвэр, шатахуун	11,127,200.00	12,127,200.00	-1,000,000.00	109.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,214,100.00	5,090,750.00	3,123,350.00	62.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00	00.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	4,837,358.00	-1,837,358.00	161.2
2105	Нормативт зардал	500,000.00	500,000.00	00.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00	00.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.00	20,000,000.00	00.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	6,000,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	14,000,000.00	14,000,000.00	00.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	9,395,200.00	9,395,200.00	00.00	100.0
210702	Дотоод албан томилолт	9,395,200.00	9,395,200.00	00.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,996,000.00	6,986,000.00	10,000.00	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,880,000.00	4,880,000.00	00.00	100.0

210803	Даатгалын үйлчилгээ	1,618,000.00	1,618,000.00	00.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	203,500.00	193,500.00	10,000.00	95.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	00.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	247,500.00	00.00	100.0
210807	Газрын төлбөр	25,000.00	25,000.00	00.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	1,000,000.00	00.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00	00.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	00.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	545,231,000.00	543,971,256.00	1,259,744.00	99.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	545,231,000.00	543,971,256.00	1,259,744.00	99.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	545,231,000.00	543,971,256.00	1,259,744.00	99.8

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	1,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	1,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	1,000,000.00
210401	Бичиг хэрэг	0.00	1,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	1,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	1,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1,000,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		